



БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2026 оны 03 сарын 04 өдөр

Дугаар А/164

Булган сум

Гүйцэтгэгчид гэрээ байгуулах
эрх олгох тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1 дэх заалт, 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 30 дугаар зүйлийн 30.1 дэх хэсэг, Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2025 оны 12 дугаар сарын 05-ны өдрийн хуралдааны XII/90 дүгээр тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Байгаль хамгаалах сангийн хөрөнгө оруулалтаар хэрэгжих “Хөрсний доройтлыг бууруулж, усыг зохистой ашиглах зорилгоор дулаан цэвэр хэрэглээний халуун усны шугам шинээр татах 500м (Булган сум 9,10,11 дүгээр орон сууц)” ажлыг гүйцэтгэх гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах үнэлгээний хорооны 2026 оны 02 дугаар сарын 12-ны өдрийн хурлын зөвлөмжийн дагуу гүйцэтгэгчээр шалгарсан “Хулдын бүлээн” ХХК-тай 1,019,950,000 (нэг тэрбум арван есөн сая есөн зуун тавин мянга) төгрөгөөр гэрээ байгуулах эрхийг Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар (Ү.Бямбасүрэн)-т олгосугай.

2.Гүйцэтгэж буй ажилд чанарын болон хугацааны хяналт тогтмол тавьж, хүлээн авахыг Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар (Ү.Бямбасүрэн)-т үүрэг болгосугай.

3.Тус хөрөнгийг холбогдох хууль, журам, гэрээний дагуу хүлээн авч данс бүртгэлд бүртгэн, хөрөнгийн ашиглалт, хадгалалт, хамгаалалтад хяналт тавихыг “Булган-Мээж” ОНӨХХК-ийн захирал (Г.Ганбаатар)-д даалгасугай.

4.Гэрээнд заасан ажлыг холбогдох хууль, журам, стандарт, зураг, төсвийн дагуу гүйцэтгэж хүлээлгэн өгөхийг “Хулдын бүлээн” ХХК-ийн захирал (П.Нямдорж)-д даалгасугай.

5.Гэрээнд тусгах нөхцөл шаардлагыг 1 дүгээр, тухайн төсөл арга хэмжээг гүйцэтгэхээр санал болгосон инженер, техникийн ажилчид, машин механизмын жагсаалтыг 2 дугаар хавсралтаар тус тус баталж, заагдсан үзүүлэлтүүдийг гэрээнд тусган хяналт тавин ажиллахыг хариуцсан албан тушаалтнуудад даалгасугай.

6326010215

6.Тус ажлын санхүүжилтийг холбогдох хууль тогтоомж, гэрээний дагуу Байгаль хамгаалах сангийн хөрөнгө оруулалтаас санхүүжүүлэхийг тус сангийн нягтлан бодогч (Б.Очирсүрэн)-д зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА



Д.ПҮРЭВ-ОЧИР

Аймгийн Засаг даргын 2024 оны
03 дугаар сарын 04-ний өдрийн
...А/кы... дугаар захирамжийн 1 дүгээр хавсралт




Гэрээнд тусгах нөхцөл шаардлага

д/д	Нөхцөл шаардлага	Мөнгөн дүн	Хариуцах албан тушаалтан
1	2	3	4
1	Магадлашгүй ажил	17,363,258	Ү.Бямбасүрэн
2	Захиалагчийн техник хяналтын зардал	17,363,258	Ү.Бямбасүрэн
3	Зураг төсөл зохиогчийн хяналтын зардал	8,681,629	Ү.Бямбасүрэн
4	Инженер хайгуул, зураг төслийн ажлын дүн	20,000,000	Ү.Бямбасүрэн
5	Нормчлолын сан	1,562,693	Ү.Бямбасүрэн
6	Алданги	Хоног тутамд гүйцэтгээгүй үүргийн үнийн дүнгийн 0.5 хувь байна. Нийт алдангийн хувь гүйцэтгээгүй үүргийн 10 хувиас хэтрэхгүй байна.	Б.Ариунболд
7	Чанарын баталгаа	Гэрээний үнийн дүнгийн 5 хувь, чанарын баталгааг байршуулах банк, дансыг гэрээнд тусгана.	Б.Ариунболд Ү.Бямбасүрэн
8	Гүйцэтгэлийн баталгаа	3 хувь	Б.Ариунболд
9	Ажил гүйцэтгэх хугацаа	Хуанлийн 300 хоног	Ү.Бямбасүрэн

--о00о--

Аймгийн Засаг даргын 2026 оны
03 дугаар сарын 04-ны/ний өдрийн
А/164 дугаар захирамжийн 2 дугаар хавсралт



Тухайн төсөл арга хэмжээг гүйцэтгэхээр санал болгосон инженер, техникийн
ажилчид, машин механизмын жагсаалт

Инженер, техникийн ажилчид			Хариуцах албан тушаалтан
д/д	Албан тушаал	Ажилтны нэр	тушаалтан
1	2	3	4
1	Барилгын инженер	Б.Дөлгөөн	Ү.Бямбасүрэн
2	Дулааны инженер	Ж.Мэндхүү	
3	Ус хангамж, ариутгах татуургын инженер	Н.Кадирбек	
4	Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн ажилтан	Ч.Мягмарсүрэн	
Машин механизмын жагсаалт			Ү.Бямбасүрэн
№	Машин механизмын нэр	Улсын дугаар	
1	Автокран	8881 ОРА	
2	Ачааны автомашин	8198 ОРН	
3	Эксковатор	7307 УБ	

--o00o--